



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Тариат сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2025/06-НА-СТА-ТШЗ

| | |
|---|--|
| <p>Цахим хуудас: www.open.audit.mn</p> <p>Архангай аймаг 2025 он</p> | <p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитор В.Цогжаргал Цахим хаяг: Tsogjargalb@audit.gov.mn</p> |
|---|--|

1. **ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025-02-17 № 10

танай _____-ны № _____-Т

ТАРИАТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Р.ТҮМЭНБАЯР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Тариат сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Тариат сумын ЗДТГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Албан хаагчдын хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны урамшууллыг зөрүүтэй тооцож, албан татварыг суутгаагүй нийт 5,583.7 мянган төгрөгийг илүү олгосон;
2. Сумын засаг даргын 2024 оны 4 удаагийн захирамжаар улс төрийн албан хаагчдад нийт 8,884.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг улирал бүр олгосон;

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.3 дахь заалтуудыг тус тус зөрчсөн, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор "Төрийн захиргааны албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам" батлагдсаны дагуу нийт 37,302.0 мянган төгрөгийг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны урамшуулалд олгосон байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь тайлант онд орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагааны зардал, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг, бусад, орон нутгийн нөөц хөрөнгө, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, гамшгаас сэргийлэх сургалт, сурталчилгаа, улсын баяр наадам арга гэсэн 7 хэмжээг хэрэгжүүлэхээр 1,197,233.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 1,172,147.2

мянган төгрөгийг зарцуулж, 25,085.9 мянган төгрөгийн төсвийн үлдэгдлийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 9 зорилт 98 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 89 арга хэмжээ нь дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн үр дүндээ хүрсэн 9 арга хэмжээ 70 хувийн гүйцэтгэлтэй байна. Тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсээс 82.9 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

| Данс | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------|---|-------------------|-------------------|
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 75,242,311.20 | 78,250,712.28 |
| 33 | АВЛАГА | 0.00 | 1,273,889.08 |
| 335 | Бусад авлага | 0.00 | 1,273,889.08 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 0.00 | 1,273,889.08 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 75,242,311.20 | 72,342,823.20 |
| 351 | Түүхий эд материал | 56,000.00 | 0.00 |
| 3511 | Тусгай зориулалттай материал | 56,000.00 | 0.00 |
| 354 | Хангамжийн материал | 75,186,311.20 | 72,342,823.20 |
| 3541 | Бичиг хэргийн материал | 2,537,891.00 | 2,462,775.00 |
| 3542 | Аж ахуйн материал | 37,030,211.20 | 24,588,048.20 |
| 3543 | Сэлбэг хэрэгсэл | 7,426,000.00 | 445,000.00 |
| 3545 | Барилгын засварын материал | 13,050,000.00 | 12,362,000.00 |
| 3547 | Бусад хангамжийн материал | 15,142,209.00 | 32,485,000.00 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 0.00 | 4,634,000.00 |
| 363 | Тэжээлийн нөөц | 0.00 | 4,634,000.00 |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 3,130,785,276.65 | 3,306,948,549.89 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 3,130,785,276.65 | 3,306,948,549.89 |
| 392 | Биет хөрөнгө | 3,094,133,109.98 | 3,270,296,383.22 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 982,747,200.00 | 1,080,507,408.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -190,702,136.01 | -229,804,703.88 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 421,528,733.00 | 570,862,427.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -180,790,471.33 | -189,556,529.46 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 180,286,081.15 | 152,147,679.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -100,537,455.86 | -62,208,734.83 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 58,268,279.00 | 35,717,900.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -28,109,786.03 | -12,263,942.46 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 3,262,173,498.25 | 3,210,868,632.25 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -1,310,945,732.19 | -1,286,188,652.40 |
| 39217 | Ном | 214,900.00 | 214,900.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 36,652,166.67 | 36,652,166.67 |
| 39301 | Програм хангамж | 5,215,000.00 | 5,215,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -4,960,833.33 | -4,960,833.33 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 36,398,000.00 | 36,398,000.00 |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 3,206,027,587.85 | 3,385,199,262.17 |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 3,206,027,587.85 | 3,385,199,262.17 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 3,206,027,587.85 | 3,385,199,262.17 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 374,736,782.32 | 374,736,782.32 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 2,466,976,420.34 | 2,646,148,094.66 |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | 2,466,976,420.34 | 2,466,976,420.34 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | 179,171,674.32 |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 364,314,385.19 | 364,314,385.19 |
| VI | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 3,206,027,587.85 | 3,385,199,262.17 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---------|--|------------------|------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,475,877,049.00 | 1,808,665,582.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 352,977,763.00 | 552,364,924.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 352,977,763.00 | 552,364,924.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 6,507,763.00 | 8,189,494.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,507,763.00 | 8,189,494.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 328,970,000.00 | 509,056,430.00 |

Архангай аймгийн Тариат сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|--------|---|------------------|------------------|
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 17,500,000.00 | 35,119,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,122,899,286.00 | 1,256,300,658.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 12,330,086.00 | 65,567,558.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 0.00 | 9,544,299.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 346,800.00 | 38,344,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 11,983,286.00 | 2,645,259.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0.00 | 15,034,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 1,110,569,200.00 | 1,190,733,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,110,569,200.00 | 1,190,733,100.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,412,869,504.56 | 1,629,493,907.68 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,412,869,504.56 | 1,609,493,907.68 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,352,936,853.92 | 1,515,686,631.81 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 432,172,850.58 | 683,506,183.00 |
| 210101 | Үндсэн цалин | 310,186,711.58 | 426,500,896.00 |
| 210102 | Нэмэгдэл | 97,763,254.00 | 228,076,537.00 |
| 210104 | Урамшуулал | 24,222,885.00 | 28,928,750.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 55,244,401.00 | 84,131,384.05 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 37,936,455.21 | 57,057,321.31 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,463,112.08 | 6,862,495.33 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,484,152.83 | 3,418,047.75 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 850,968.18 | 3,358,702.75 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,509,712.70 | 13,434,816.91 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 27,498,233.78 | 33,600,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,305,233.78 | 16,176,900.00 |
| 210302 | Түлш, халаалт | 17,020,000.00 | 17,293,100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 173,000.00 | 130,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 62,883,880.00 | 49,796,683.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,490,250.00 | 4,177,186.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 41,735,580.00 | 22,343,004.70 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,818,630.00 | 3,840,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 389,500.00 | 96,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 11,654,674.00 | 14,140,257.30 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 795,246.00 | 5,200,235.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 22,212,500.00 | 70,100,750.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 13,000,000.00 | 12,690,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,212,500.00 | 57,410,750.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 9,870,000.00 | 12,790,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,870,000.00 | 12,790,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 345,175,333.00 | 119,184,967.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 341,616,486.00 | 117,485,967.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 185,938.00 | 500,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 300,000.00 | 500,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 50,000.00 | 176,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 450,000.00 | 450,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 72,909.00 | 73,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 2,500,000.00 | 0.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 397,879,655.56 | 462,576,164.76 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 56,476,791.00 | 80,747,508.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 946,200.00 | 3,355,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 340,456,664.56 | 378,473,156.76 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 59,932,650.64 | 93,807,275.87 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 4,000,000.00 | 66,731,900.00 |

Архангай аймгийн Тариат сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|--------|---|---------------|----------------|
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.00 | 17,509,900.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 0.00 | 45,222,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,000,000.00 | 4,000,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 55,932,650.64 | 27,075,375.87 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 55,932,650.64 | 26,775,375.87 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 300,000.00 |
| | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 0.00 | 20,000,000.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | 0.00 | 20,000,000.00 |
| 221001 | Их засвар | 0.00 | 20,000,000.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 63,007,544.44 | 179,171,674.32 |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 63,007,544.44 | 179,171,674.32 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---------|---|------------------|------------------|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 1,129,407,049.00 | 1,264,490,152.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 6,507,763.00 | 8,189,494.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 6,507,763.00 | 8,189,494.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 6,507,763.00 | 8,189,494.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,507,763.00 | 8,189,494.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,122,899,286.00 | 1,256,300,658.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 12,330,086.00 | 65,567,558.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 0.00 | 9,544,299.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 346,800.00 | 38,344,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 11,983,286.00 | 2,645,259.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0.00 | 15,034,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 1,110,569,200.00 | 1,190,733,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,110,569,200.00 | 1,190,733,100.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 1,068,553,149.00 | 1,198,910,152.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,068,553,149.00 | 1,198,910,152.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,008,620,498.36 | 1,105,102,876.13 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 433,174,250.70 | 684,070,470.76 |
| 210101 | Үндсэн цалин | 312,952,887.70 | 437,110,700.76 |
| 210102 | Нэмэгдэл | 96,234,328.00 | 212,569,502.00 |
| 210104 | Урамшуулал | 23,987,035.00 | 34,390,268.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 54,073,100.88 | 84,728,485.37 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36,820,400.00 | 58,006,551.19 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,331,800.00 | 6,824,300.13 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,465,400.00 | 4,859,129.84 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 866,400.00 | 1,525,792.40 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,589,100.88 | 13,512,711.81 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 27,759,633.78 | 33,600,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 10,459,633.78 | 16,176,900.00 |
| 210302 | Түлш, халаалт | 17,100,000.00 | 17,293,100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 200,000.00 | 130,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 61,079,230.00 | 46,465,862.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,990,300.00 | 3,585,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 36,860,600.00 | 20,840,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,826,330.00 | 3,840,000.00 |

Архангай аймгийн Тариат сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | |
|--------|---|----------------|----------------|
| 210404 | Ном, хэвлэл | 420,600.00 | 96,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 15,126,200.00 | 17,066,062.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 855,200.00 | 1,038,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 22,520,500.00 | 58,000,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 13,000,000.00 | 14,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,520,500.00 | 44,000,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 9,870,000.00 | 12,790,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,870,000.00 | 12,790,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 348,786,683.00 | 114,575,259.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 345,227,836.00 | 111,376,259.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 185,938.00 | 500,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 300,000.00 | 500,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 50,000.00 | 176,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 450,000.00 | 450,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 72,909.00 | 73,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 2,500,000.00 | 1,500,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 51,357,100.00 | 70,872,299.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 49,800,000.00 | 67,042,299.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,557,100.00 | 3,830,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 59,932,650.64 | 93,807,275.87 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 4,000,000.00 | 66,731,900.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 0.00 | 17,509,900.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 0.00 | 45,222,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,000,000.00 | 4,000,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 55,932,650.64 | 27,075,375.87 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 55,932,650.64 | 26,775,375.87 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 300,000.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 60,853,900.00 | 65,580,000.00 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 60,853,900.00 | 65,580,000.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | 60,853,900.00 | 65,580,000.00 |
| 221001 | Их засвар | 0.00 | 20,000,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 60,853,900.00 | 45,580,000.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -60,853,900.00 | -65,580,000.00 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Д/Д | Үзүүлэлт | Засгийн газрын сан | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | ЗГ-н хувь оролцооны дүн |
|-----|---------------------------------------|--------------------|-----------------------|----------------------|-------------------------|
| 1 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 374,736,782.32 | 364,314,385.19 | 2,403,968,875.90 | 3,143,020,043.41 |
| 2 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | | | | |
| 3 | Тайлант үеийн үр дүн | | | 63,007,544.44 | 63,007,544.44 |
| 4 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 374,736,782.32 | 364,314,385.19 | 2,466,976,420.34 | 3,206,027,587.85 |
| 5 | 2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 374,736,782.32 | 364,314,385.19 | 2,466,976,420.34 | 3,206,027,587.85 |
| 6 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 179,171,674.32 | 179,171,674.32 |
| 7 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 374,736,782.32 | 364,314,385.19 | 2,646,148,094.66 | 3,385,199,262.17 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү дүн | Хувь |
|--------|--|------------------|------------------|----------------|--------|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,197,233,100.00 | 1,172,147,218.13 | 25,085,881.87 | 97.9 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,157,233,100.00 | 1,132,147,218.13 | 25,085,881.87 | 97.83 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,090,501,200.00 | 1,065,415,318.13 | 25,085,881.87 | 97.7 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 694,412,900.00 | 684,070,470.76 | 10,342,429.24 | 98.51 |
| 210101 | Үндсэн цалин | 443,032,100.00 | 437,110,700.76 | 5,921,399.24 | 98.66 |
| 210102 | Нэмэгдэл | 179,083,200.00 | 212,569,502.00 | -33,486,302.00 | 118.7 |
| 210104 | Урамшуулал | 72,297,600.00 | 34,390,268.00 | 37,907,332.00 | 47.57 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 86,801,700.00 | 84,728,485.37 | 2,073,214.63 | 97.61 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 59,025,200.00 | 58,006,551.19 | 1,018,648.81 | 98.27 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,944,100.00 | 6,824,300.13 | 119,799.87 | 98.27 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,555,300.00 | 4,859,129.84 | 696,170.16 | 87.47 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,388,800.00 | 1,525,792.40 | -136,992.40 | 109.86 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,888,300.00 | 13,512,711.81 | 375,588.19 | 97.3 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 33,600,000.00 | 33,600,000.00 | 0.00 | 100 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 16,020,100.00 | 16,176,900.00 | -156,800.00 | 100.98 |
| 210302 | Түлш, халаалт | 17,329,900.00 | 17,293,100.00 | 36,800.00 | 99.79 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 250,000.00 | 130,000.00 | 120,000.00 | 52 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 48,796,600.00 | 46,465,862.00 | 2,330,738.00 | 95.22 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,585,600.00 | 3,585,600.00 | 0.00 | 100 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,840,200.00 | 20,840,200.00 | 0.00 | 100 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,840,000.00 | 3,840,000.00 | 0.00 | 100 |
| 210404 | Ном, хэвлэл | 96,000.00 | 96,000.00 | 0.00 | 100 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 19,396,800.00 | 17,066,062.00 | 2,330,738.00 | 87.98 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,038,000.00 | 1,038,000.00 | 0.00 | 100 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 72,700,000.00 | 72,700,000.00 | 0.00 | 100 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 24,700,000.00 | 24,700,000.00 | 0.00 | 100 |
| 210604 | Урсгал засвар | 48,000,000.00 | 48,000,000.00 | 0.00 | 100 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 12,790,500.00 | 12,790,500.00 | 0.00 | 100 |
| 210702 | Дотоод албан томилолт | 12,790,500.00 | 12,790,500.00 | 0.00 | 100 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 112,569,500.00 | 102,230,000.00 | 10,339,500.00 | 90.82 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 109,370,500.00 | 99,031,000.00 | 10,339,500.00 | 90.55 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 500,000.00 | 500,000.00 | 0.00 | 100 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 500,000.00 | 500,000.00 | 0.00 | 100 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оншилгоо | 176,000.00 | 176,000.00 | 0.00 | 100 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 450,000.00 | 450,000.00 | 0.00 | 100 |
| 210807 | Газрын төлбөр | 73,000.00 | 73,000.00 | 0.00 | 100 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,500,000.00 | 1,500,000.00 | 0.00 | 100 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 28,830,000.00 | 28,830,000.00 | 0.00 | 100 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 25,000,000.00 | 25,000,000.00 | 0.00 | 100 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,830,000.00 | 3,830,000.00 | 0.00 | 100 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 66,731,900.00 | 66,731,900.00 | 0.00 | 100 |

Архангай аймгийн Тариат сумын ЗДТГ-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

| | | | | | |
|---------|---|------------------|------------------|---------------|--------|
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 66,731,900.00 | 66,731,900.00 | 0.00 | 100.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 17,509,900.00 | 17,509,900.00 | 0.00 | 100.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 45,222,000.00 | 45,222,000.00 | 0.00 | 100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,000,000.00 | 4,000,000.00 | 0.00 | 100.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 40,000,000.00 | 40,000,000.00 | 0.00 | 100.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | 40,000,000.00 | 40,000,000.00 | 0.00 | 100.00 |
| 221001 | Их засвар | 40,000,000.00 | 40,000,000.00 | 0.00 | 100.00 |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,197,233,100.00 | 1,172,147,218.13 | 25,085,881.87 | 97.9 |
| 132 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,190,733,100.00 | 1,163,957,724.13 | 26,775,375.87 | 97.75 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,190,733,100.00 | 1,163,957,724.13 | 26,775,375.87 | 97.75 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 6,500,000.00 | 8,189,494.00 | -1,689,494.00 | 125.99 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 6,500,000.00 | 8,189,494.00 | -1,689,494.00 | 125.99 |
| 2 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | | 1 | | 100.00 |
| 3 | Төсвийн байгууллага | | 1 | | 100.00 |
| 5 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | | 25 | | 100.00 |
| 6 | Удирдах ажилтан | | 10 | | 100.00 |
| 7 | Гүйцэтгэх ажилтан | | 10 | | 100.00 |
| 8 | Үйлчлэх ажилтан | | 4 | | 100.00 |
| 9 | Гэрээт ажилтан | | 1 | | 100.00 |
| 24 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | | 25 | | 100.00 |
| 25 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | | 8 | | 100.00 |
| 33 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | | 7 | | 100.00 |
| 34 | Гэрээт ажилтан | | 1 | | 100.00 |
| 35 | Улс төрийн албан хаагч (УТ) | | 9 | | 100.00 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

| Д/Д | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|--------|---|---------------|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 65,567,558.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 65,567,558.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 65,267,558.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 22,345,259.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 22,345,259.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 42,922,299.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 42,922,299.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 300,000.00 |
| | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 300,000.00 |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 300,000.00 |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 65,567,558.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 65,567,558.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 9,544,299.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 38,344,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,645,259.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 15,034,000.00 |

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 80,488.6 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрч, санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Залруулсан алдаа:

Тайлант оны элэгдлийн зардлыг 40,488.6 мянган төгрөгөөр дутуу тусгасан, хөрөнгийн зардлыг 40,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгасныг аудитын явцад залрууллаа.

Энэ нь НББ-ын тухай хуулийн 5.1.4, 13.1, 15.1, 15.2 дахь заалтууд, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх батламж мэдэгдлийн хангахгүй байна.

Аудитаар залруулаагүй 19,752.7 мянган төгрөгийн зөрчил² илэрч 5,583.7 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 14,169.0 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй 4 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 19,752.7 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 13,468.9 мянган төгрөгөөс их байх тул **Хязгаарлалттай дүгнэлт** өглөө.

3.1 Төлбөрийн акт

3.1.1. Тайлант онд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийг 6 албан хаагчид олгохдоо сүүлийн сарын цалинг 6 дахин нэмэгдүүлж зөрүүтэй тооцон, ХХОАТ-ыг суутгалгүй нийт 5,583,700 төгрөгийн тэтгэмжийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.3-д "Мөнгөн урамшууллын хэмжээг тодорхойлохдоо Төрийн албаны тухай хуулийн 51.3-т заасныг баримтлан тухайн төрийн захиргааны алба хаагчийн сүүлийн 12 сарын үндсэн цалингийн дунджийг 6 дахин нэмэгдүүлж тооцно", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д "Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно", 6.3.1-д "Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 7 дугаар зүйлийн 7.1-д "Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна, 7.1.1-д "Ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого", 21 дүгээр зүйлийн 21.1-д "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар ... албан татвар ногдуулна" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2 Албан шаардлага

3.2.1. Тайлант онд сумын Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн Б/06, 2024 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн Б/09, 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн Б/12 дугаар, 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн Б/15 дугаар захирамжаар Тэрх, Цагааннуур, Хорго, Бөөрөлжүүт, Суман, Алтаад багийн Засаг дарга, орлогч дарга нарт нийт 8,883,961 төгрөгийн үр дүнгийн урамшууллыг олгосон байна. Засаг даргын захирамжид дурдсан Төрийн албаны тухай хуулийн 52.1 дэх заалт нь улс төрийн албан тушаалд хамаарахгүй бөгөөд тус хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т төрийн захиргааны, төрийн тусгай албан тушаалыг төрийн жинхэнэ албан тушаал гэж хуульчилсан байхад сумын Засаг дарга нь

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

багийн Засаг даргын албан тушаалыг төрийн жинхэнэ албан тушаалтай адилтгаж үр дүнгийн урамшуулал олгожээ.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 10.3-д "Энэ хуулийн 10.1.2, 10.1.3-т заасан албан тушаалыг төрийн жинхэнэ албан тушаал гэнэ", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" гэсний 4.1.3-д "Үр ашигтай байх", 4.1.6 "Сахилга баттай байх", 4.1.9 "Хариуцлагатай байх" 4.2.1-д "Зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3.2.2. Сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн Б/21 дүгээр захирамж, ЗДТГ-ын даргын 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн Б/24 дүгээр тушаалаар ...санхүүгийн нэгдсэн тайлан, төсөвт байгууллагын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн цаглаврын дагуу үнэн зөв гаргаж зөрчилгүй ажилласан тул санхүү албан дарга, төрийн сангийн мэргэжилтэн, нягтлан бодогч, нярав нарт үндсэн цалинг 100 хувиар тооцож цалингийн сангаас 5,285.0 мянган төгрөгийн урамшуулал буюу шагнал олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна..

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3.2.3. Тус байгууллага нь тайлант онд дотоод хяналт шалгалт хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" гэсний 16.5.2-т "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т "Засгийн газраас тогтоосон нийтлэг журмыг үндэслэн харьяа байгууллага, аж ахуйн нэгж өөрийн аппаратад дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг баталж мөрдүүлнэ", Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 1.3-т "Аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай байна гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна..

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, цаашид давтан гаргахгүй байх, дотоод хяналт шалгалтыг хийж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | /мян.төг/ | | | |
|--|-------------|-----------------|-----------|----------------|-----------------|-----------------|
| | | | Үүнээс | | Албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хөдөө орон нутагт суурьшилтай ажилласны мөнгөн урамшууллаас 6 албан хаагчид нийт 5,583.7 мянган төгрөгийг илүү олгосон байна. | 1 | 5,583.7 | 1 | 5,583.7 | | |
| Улс төрийн албан тушаалтнуудад 8,884.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг цалингийн сангаас олгож, зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн байна. | 1 | 8,884.0 | | | 1 | 8,884.0 |
| Албан хаагчдад 5,285.0 мянган төгрөгийн урамшуулал буюу шагналыг цалингийн сангаас олгосон байна. | 1 | 5,285.0 | | | 1 | 5,285.0 |
| Тус байгууллага нь тайлант онд дотоод хяналт шалгалт хэрэгжүүлээгүй байна. | 1 | 0.0 | | | 1 | 0.0 |
| Нийт дүн | 4 | 19,752.7 | 1 | 5,583.7 | 3 | 14,169.0 |